

“САРЫН ШИЛДЭГ АЖИЛТАН” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /цаашид “байгууллага” гэх/ -ын ажилтаны үйл ажиллагааны үр дүн идэвхи санаачилга, ажлын ололт амжилт, бүтээлч байдал, байгууллагын ёс зүй, нэр хүндийг эрхэмлэн дээдэлж төрийн албан хаагчийн үйлчилгээний стандарт, соёл дэг журмыг сахин ажиллаж байгаа албан хаагчийг тухайн сарын “Сарын шилдэг ажилтан”-аар шалгаруулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 “Сарын шилдэг ажилтан”-ыг шалгаруулахдаа тухайн ажилтаны мэдлэг, мэргэшлийн ур чадвар, ажлын туршлага, үр дүнгийн бодит үнэлгээг харгалзан үзнэ.

1.3 “Сарын шилдэг ажилтан”-д олгох урамшууллыг байгууллагын холбогдох зардлаас гаргана.

Хоёр. Урамшууллын хэлбэр, хэмжээ

2.1 “Сарын шилдэг ажилтан”-д олгох урамшуулал нь ажилтаны гэрэл зургийг байгууллагын мэдээллийн самбарт нэг улирлын турш байрлуулна.

Гурав. Шалгаруулах нөхцөл

3.1 Байгууллагын “Сарын шилдэг ажилтан”-ыг дараах ерөнхий үзүүлэлтээр шалгаруулна.

№	Ерөнхий үзүүлэлтийн нэр	Оноо
1.	Тухайн сарын ур чадварын үнэлгээ	0-50
2.	Байгууллагын хүрээнд мөрдөж буй журам, дүрэм, стандарт болон Монгол улсын хууль тогтоомжийг хэрхэн мөрдөж байгаа байдал	0-10
3.	Ажлын цаг ашиглалт, ирцийн байдал	0-10
4.	Шинийг санаачлан нэвтрүүлсэн байдал	0-10
5.	Ажил үүрэгтэй нь холбогдуулан иргэд, байгууллагаас болон бусад ажилтанаас ирүүлсэн үнэлгээ, гомдол санал байгаа эсэх	0-20
	НИЙТ	100

3.2 “Сарын шилдэг ажилтан”-аар шалгарсан ажилтаныг дахин шилдэг ажилтанаар шалгаруулж болно.

Дөрөв. Нэр дэвшүүлэх шийдвэрлэх

4.1 Энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтээр 80 буюу түүнээс дээш оноо авсан ажилтаныг тухайн хэлтсийн нийт ажилтаны хурлаар хэлэлцүүлж, нэр дэвшигчийн материалыг Захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн удирдлагад сарын сүүлийн долоо хоногийн Даваа гаригт хүргүүлнэ.

4.2 Хэлтсийн удирдах албан тушаалтан харъяалах нэгжийн шалгуур үзүүлэлтийн оноог гаргасан тайланг энэхүү журмын 4.1-д заасан хугацаанд хүргүүлнэ.

4.3 Хэлтэс бүрээс санал болгон ирүүлсэн ажилтануудыг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шалгуур үзүүлэлтээр хамгийн их оноо авсан ажилтаныг “Сарын шилдэг ажилтан”-аар шалгаруулна.

4.4 Тухайн сард 80 буюу түүнээс дээш оноог хангасан ажилтан гараагүй тохиолдолд “Сарын шилдэг ажилтан”-ыг шалгаруулахгүй.

4.5 “Сарын шилдэг ажилтан”-д олгох шагнал урамшууллыг байгууллагын Дарга, Захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн удирдлага гардуулна.

Тав. Бусад

5.1 Энэхүү журмын хэрэгжилтэд Захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн удирдлага болон бусад хэлтэс хамтран хяналт тавина.

5.2 Байгууллагын “Сарын шилдэг ажилтан”-ы талаарх мэдээллийн санг Захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн удирдлага бүрдүүлэн хөтлөх бөгөөд ажилтаныг жилийн эцэст шагнаж урамшуулах, гадаад, дотоодын сургалтанд хамруулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд “Сарын шилдэг ажилтан”-д давуу эрхтэй олгож болно.